

“Өөрийн үндэсний хэл бичигт сайн суралцах нь олон төрлийн мэдлэг мэргэжилтэй болохын анхны шат болно. Анхны шат дээр гишгэлгүй, шууд хоёр, гуравдугаар шатанд авирч болдоггүй шиг, үндэсний хэл бичигт сайн суралцахгүйгээр шууд мэргэжлийг эзэмшихэд их бэрхшээлтэй байх болно.”⁶

“Ертөнцийн гурав”-аас орчуулах гэж оролдсон минь

А.Цэрэнчулуун

Товч утга: “Ертөнцийн гурав” бол ардын аман зохиолын сонгодог бүтээл, танин мэдэхүй, амьдралын гүн ухааны аястай судалгаа, сургаал, санамжийн хураангуй юм. “Ертөнцийн гурав”-ыг монгол түмэн нүүдлийн соёл иргэншлийн олон талт амьдралынхаа туршид туурвижээ. “Ертөнцийн гурав”-ын зарим нь эргэх цагийн аясаар хуучирч гээгдэхийн зэрэгцээ хөгжил, хувьслын дагуу шинээр сэлбэгдэн баяжиж байдаг байна.

Орчуулах, хэлмэрчлэх хоорондоо төстэй боловч орчуулах нь эхийг цаг хугацаанд баригдалгүй тайван ашиглаж, засаж найруулж, улам төгс болгох боломжтой байдаг бол хэлмэрчлэх, ялангуяа хам хэлмэрчлэх нь өгөгдсөн цагт яриаг чихэвчээр сонсоод, шууд өсгүүрээр дамжуулан хөрвүүлэх үйл ажиллагаа юм. Хам хэлмэрчлэх нь нэлээд их туршлагажсан, тухайн хэлийг эх хэл шигээ эзэмисэн хүний хийх ажил.

Түлхүүр үг: Гурвын тооны бэлгэдэл, ертөнцийн гурав, орчуулах, хэлмэрчлэхэд баримтлах зарчим, орчуулах, хэлмэрчлэхийн ялгаа, орчуулга

1. Орчуулах, хэлмэрчлэх хийгээд түүнд анхаарах зүйл, баримтлах зарчим

1.1. Орчуулах хийгээд хэлмэрчлэх

- Тодорхой нэгэн голдуу бичгийн хэлбэртэй эх хэл-нээс зорьж буй буюу орчуулга хийж буй хэлэнд хөрвүүлэхийг **орчуулах**⁶ гэнэ.
- Орчуулах, хэлмэрчлэх явцад буй болсон бүтээгдэхүүнийг **орчуулга** гэнэ. Орчуулгын болон хэлмэрчлэх явцад **хэлний** болон **соёлын** өвөрмөц ухагдахууныг дамжуулах болой⁷.
- Орчуулах, хэлмэрчлэх хоёрын зонхилох ялгаа нь гэвэл **орчуулах** явцад эх материалыг ахин дахин харах, лавлах боломжтой бичгийн, эсвэл, өөр дуу хадгалах хэрэгсэлд хадгалаастай байдаг бол **хэлмэрчлэх** явцад эх материал хадгалаастай байдаггүй, үлддэггүй, зарчмын хувьд яриад өнгөрдөгт байгаа юм.
- Орчуулах нь цаг хугацаанд баригдахгүй, лавлаж харах, хүнээс асуух, ахин шалгах, найруулан засах боломжтой байдаг бол хэлмэрчлэх нь өгсөн цагт

⁶ Wikipedia Online лавлах

⁷ www.google.de

багтаан шууд өөрийн мэдлэгт тулгуурлан хийх ажил бөгөөд нөгөө хүн яриад өнгөрсөн бол ахин засаж залруулах боломж үгүй болох авай. Ялангуяа хам хэлмэрчлэхэд өгүүлэгч, хөрвүүлэгч хоёр нүүр нүүрээ харан цуг суудаггүй, өгүүлэгч индэрт, хэлмэрч кабинд суух болой.

1.2. Орчуулгын хэлбэрүүд:

- **Авиан зүйн орчуулга**, алив оноосон нэр, хүний нэр зэргийг дуудлагаар бичээд шаардлагатай бол зүүлт хийн тайлбарлана. Жишээ нь: Нью-Йорк, Улаанбаатар, айраг, гм.
- **Хадмал орчуулга**, эхийн үг бүрийг хөрвүүлэн оноож бичнэ, энэ нь эх хэлэн дэх өгүүлбэрийн бүтцийг нарийвчлан гаргах сайн талтай.
- **Үгчилсэн орчуулга**, эхийн үг, өгүүлбэр бүрийг зорьсон хэлэн дээрээ буулгана. Энэ хэлбэр судалгааны материалыг буулгахад дөхөмтэй. Мөн алив багаж, хэрэгслийг ашиглах зааварыг үгчлэн орчуулна. Үгчилсэн орчуулга ч гэсэн найруулга сайтай байх нь зүй. Хоол хийх заавар, анагаах ухааны номонд гадаад үгийг үгчлэн авахдаа монгол хэлэнд байхгүй үг, хэллэг ихээр хэрэглэн түүндээ дасч байх шиг. Ганц жишээ хэлэхэд энд тэнд **өвдөхөө** болиод **өвдөлт өгдөг**, **барилга барихаа** болиод өөрөө **баригддаг** болжээ.

1.2.1 Утгачилсан орчуулга, энэ дотроо стратегийн хоёр зорилготой, утга зохиолыг уншигчид ойлгомжтой болгон орчуулахын тулд **нутагшуулах** аргыг хэрэглэнэ. А.С.Пушкины “Алтан загасны үлгэр”-ийг Ц.Дамдинсүрэн гуай нутагшуулах аргаар гайхамшигтай сайхан орчуулсан байдаг. Харин зохиогчийн бичлэгийн арга барил, зохиогчийн ард түмний соёл, сэтгэхүйн өвөрмөц ялгааг гарган тэр ард түмний хэл соёл сэтгэлгээний онцлогыг тод томруун гарган орчуулахдаа **ондоошуулах** аргыг хэрэглэх болой. Алив судалгааны материалыг хөрвүүлэхдээ энэ аргыг хэрэглэвээс зохилтой.

1.3. Орчуулах, хэлмэрчлэхэд анхаарах зүйл, баримтлах зарчим:

Эхлээд юу хэлэх гэснийг нь, дараа нь хэлэх зүйлээ хэрхэн тодруулсныг нь, өөрөөр хэлбэл, эхлээд гол өгүүлбэрийг, дараа нь туслах өгүүлбэрийг ялгаж, салган зөв ойлгоод орчуулах аваас буруу ташаа ойлгох явдал үгүй болдог. Мөн үгийг ямар утгаар хэрэглэснийг ухаж мэдэхийн тулд ахин дахин уншиж эрэгцүүлэн бодох шаардлагатай. Мөн нэг үгийн олон утгын чухам аль болохыг лавлан харах хэрэгтэй. Нэг хэлний тайлбар толь гарын дор байх зайлшгүй шаардлагатай.

Монголчууд гурвын тоог эрхэмлэхийн учир

Монгол түмэн аль хэдийнээс, тулгын гурван чулуу тавин халуун хоол хийдэг болсноос хойш гурван юм тогтвор суурьшилтай байдгийг мэдэн гурвын тоог эрхэмлэн, бат бөх оршихын бэлгэдэл болгосон байж болох. Гурван чулууны нэг үгүй бол тогоо тогтохгүй учир тэр гурван чулуу цугтаа чандмалан байдаг, тиймээс ч “**тулгын гурван чулуу шиг туждаа хамт**” гэдэг хэлц үг гарсан биз ээ. Тийм учраас монголчууд гурван цагийн холбоос, гурван үеийн хэлхээ, эрийн гурван

наадам, гурван үеийнхэн, гурван эрдэнэ гэдэг хэллэг, гурвын тооны бэлгэдэл: гурвантаа мөргөх, гурван удаа ялаас хэлтрүүлэх, гурвантаа уучлах зэрэг үг гарсан буй заа. Гурван юм бат бөх байдгийг үндэслэн гурамсан чөдөр, гурамсан утас, гурамсан хуйв, гурамсан чагтага зэргийг хийдэг байна. Гурвын тоог дээдлэх үүднээс эрийн гурван наадмаа хийж, овоог гурав тойрон, гэрээ гурван бүслүүртэй хийдэг болжээ. Бас олон хүн нэгдмэл нэг хүчээр татах, түлхэх, угзрах, өргөхдөө нэг хоёрын гурваа гээд хүчээ нэгтгэн дайрдаг ажгуу. Дашрамд хэлэхэд аливаа хамтын ажиллагаанд гурван тал оролцвол тэгш, найдвартай байдаг. Яагаад гэвэл хамтран ажиллаж байгаа гурван талын нэг нь нөгөө хоёртоо байнга хяналт тавьж байдаг аж.

1.4. Ертөнцийн гурав

“Ертөнцийн гурав” бол нэгд монгол түмний олон үеийн турш улам улам боловсронгуй болгон туурвиж ирсэн ардын аман зохиол сонгодог бүтээл, **хоёрт** амьдрал, ахуй байдал, байгаль, цаг уурын юмс үзэгдлийн танин мэдэхүй, амьдралын гүн ухааны аястай судалгаа, **гуравт** хойч үеийнхэндээ хандсан сургаал, санамжийн хураангуй юм. Монгол түмний бахархах өв, уламжлалт ардын аман зохиолын нэг хэлбэр юм. Ертөнцийн гурвыг Ардын зохиолч Т. Галсан гуай баяжуулан гурамсан том бүтээл туурвисан нь монгол ардын аман зохиолд оруулсан нэгэн том хувь нэмэр гэлтэй.

1.5. “Ертөнцийн гурав”-ийн үүсэл

Монгол түмэн бэлчээрийн мал аж ахуй эрхлэн эргэх цагийн дөрвөн улирал, өглөө, өдөр, үдэш орой, шөнийн цагаар хээр гадаа явахдаа цаг улирлын хувьсал, өдөр шөнийн өөрчлөлт, өвс ургамлын ургах, цэцэглэх, хагдрахыг ажиглан байж тулгын гурван чулуугаа санан байж, гурван юман дээр алив юм бат тогтдогийг бодолцон “ертөнцийн гурав”-ыг зохиосон байж болох.

Ертөнцийн гурваас:

Ертөнцийн	гурван	цэмцгэр	Die drei Akkuraten der Welt	
Үүлээ	хөөсөн	тэнгэр	нэг цэмцгэр	Der klarende Himmel ist einmal akkurat.
Үнсээ	гаргасан	тулга	нэг цэмцгэр	Die von der Asche gesduberte Feuerstelle ist einmal akkurat.
Үсээ	самнасан	авгай	нэг цэмцгэр	Die Frau, die ihre Haare gekdmmt hat, ist einmal akkurat.

Ертөнцийн	гурван	цэнхэр	Die drei Blauen der Welt		
Холоос	харагдаж	байгаа	уул	нэг цэнхэр	Die Berge in der Ferne sind einmal blau.
Хонхорт	байгаа	ус	нэг цэнхэр	Das Wasser in der Tiefe ist einmal blau.	
Хорвоод	байгаа	тэнгэр	нэг цэнхэр	Der Himmel der Erde ist einmal blau.	

Ертөнцийн	гурван	чимэг	Die drei Schmuckstücke der Welt	
Сайхан	хүүхэн	гэрийн	чимэг	Eine schöne Frau ist der Schmuck des Hauses.
Сайн	морь	эрийн	чимэг	Ein schönes Pferd ist der Schmuck des Reiters.

Сагсгар мод уулын чимэг Die prachtvollen Bäume sind Schmuck des Berges.

1.6. “Ертөнцийн гурав”-ийн хөгжил, шинэчлэл

Ардын аман зохиол цаг үеэ даган байнга шинэчлэгдэн баяжихын зэрэгцээ бас зарим нь улирах цагийн аясаар хуучирч, гээгдэж байдаг байна.

Ертөнцийн гурван яншаа⁸

Хасаг тэрэг замын яншаа
Хатсан ховоо худгийн яншаа
Хөгшин нохой хотны яншаа

Die drei Mährischen der Welt

Der Karren auf der Straße ist mährisch.
Der trockene Schopfbeutel im Brunnen ist mährisch.
Der alte Hund vor der Herde ist mährisch.

Ертөнцийн гурван чимэг

Тэмээ говийн чимэг
Тэрэг хотын чимэг
Сахал эрийн чимэг

Die drei Schmückenden der Welt

Die Kamele schmücken die Wüste.
Die Autos schmücken die Stadt.
Der Bart schmückt den Mann.

Гурван цөөрүүлдэг

Фортер олширвол тэмээ цөөрдөг,
Мотоцикл олширвол адуу цөөрдөг,
Уурхай олширвол мал цөөрдөг.

Die drei weniger Machenden der Welt

Die Lieferwagen machen Kamele wenig,
Die Motordiesels machen Pferde wenig,
Die Bergbaubetriebe machen das Vieh wenig.

1.7. Ертөнц, алив юмс, үзэгдлийг танин мэдсний үүднээс зохиосон ертөнцийн гурав

Ертөнцийн гурван хоосон

Барьж тавьж байвч зүүд хоосон,
Барай торойж байвч зэрэглээ хоосон,
Бархирч архирч байвч цуурай нэг хоосон.

Die drei Leeren der Welt

Obwohl es man mit der Hand anfasst, ist der Traum leer.
Obwohl man wahrhaftig sieht, ist die Fata Morgana leer.
Obwohl man wirklich hört, ist das Echo leer.

1.8. Сургаал хайрласан ертөнцийн гураваас:

Ертөнцийн гурван сайхан

Аваагүй байхад авгай сайхан
Алаагүй байхад үнэг сайхан
Амсаагүй байхад архи сайхан

Die drei Schönen der Welt

Vor dem Heiraten ist die Frau verführerisch schön.
Vor dem Jagen ist der Fuchs (ver)lockend schön.
Vor dem Trinken ist der Schnaps anziehend schön.

⁸ Монгол улсын хүн амын 80 хувь хот суурин газар суудаг, газар сайгүй машин, мотоцикл хэрэглэх болсон үед үхэр болон тэмээн тэрэг хэрэглэх, гар худгаас ховоогоор ус татах явдал бараг үгүй болж, айлын гадаа зөнөсөн хөгшин нохой хуцаж байх нь бараг үгүй болжээ. Энэ тухай ертөнцийн гурав ч цагийн аясаар мартагдах тийшээ ханджээ.

2. Алив эхийг орчуулахад дараах зарчмыг баримтлах шаардлагатай мэт байдаг.

2.1. Орчуулах, хэлмэрчлэхэд эх сэдвийнхээ утгыг зөв ойлгох чухал

Эхлээд юу хэлэх гэснийг нь, дараа нь хэлэх гэсэн зүйлээ хэрхэн тодруулсныг нь өөрөөр хэлбэл эхлээд гол өгүүлбэрийг, дараа нь туслах өгүүлбэрийг ялгаж, салган зөв ойлгож орчуулах аваас буруу ташаа ойлгох явдал үгүй болдог.

Ялангуяа ертөнцийн гуравт гурван зүйлийн өвөрмөц онцлогыг гарган багцалсан, харьцуулан адилтгасан байдаг. Орчуулахдаа түүнийг тод томруун гаргаж өгөх аваас орчуулгын хэлээр уншиж байгаа хүнд арай илүү ойлгомжтой болох учиртай.

Үг бүрийг орчуулж болдоггүй, нэг үгийг гурав болон түүнээс дээш үгээр илэрхийлэх нь орчуулга бус тайлбар болно. Зарим үгийг тухай орны аху байдлыг мэдэхгүй, ядаад тэр оронд байнга очиж үзээгүй хүн ойлгох нь үгүй. Тухайлбал айлын гадаа хураалттай “аргал”-ыг үзээгүй, өвлийн хүйтэнд алсаас аргал түлсэн айлд ирэхдээ аргалын утааны таатай үнэрийг үнэрлэж мэдрээгүй, аргалын галд гараа ээн дулаацаж үзээгүй, бас араг үүрэн, савар барин аргал түүж үзээгүй хүн “аргал” гэдэг шидэт түлшийг үхрийн хатаасан баас гэсэн тайлбарыг уншаад аягүй бол бордооны гахайн баасархуу юм төсөөлөөд өнгөрөх биз. Намар цагийн аргал бол үнэн чанартаа олон янзын ургамал орсон ахилуун үнэрт шахмал юм. Бас нэг жишээ хэлье. Бидний амтархан уудаг “айраг”-ийг “күмисс” (гүүний сүү) гээд ч “гүүний эсгэсэн сүү” гээд ч урд айраг гэдгийг амсаж үзээгүй, Булган, Ар-, Өвөрхангай, Дундговийн айрагны амтанд ороогүй хүн тун тааруухнаар төсөөлөх биз. Тэр ч бүү хэл “гэр”-ийг эсгий майхан хэмээн орчуулахаар юу болох билээ. “Зөөврийн сууц” гэвэл арай тохилог юм төсөөлөгдөх жишээтэй. Тэгэхлээр энэ мэт үгийг орчуулахын оронд монгол нэрээр нь зүтгүүлэх хэрэгтэй юм шиг санагдана.



Монголоос аль нэг гадаад хэл рүү үндэсний онцлог, хэл, соёлын өвөрмөц талыг харуулсан, орчууллаа гээд утга санаа нь бүрэн гарахгүй, буруу ташаа ойлголт өгч болох үгийг орчуулах биш тэр хэвээр нь галиглан оруулаад, зүүлт хийн сайтар тайлбар хийж байваас зохилтой мэт санагдана.

2.2. Даяарчлалын үед манайд байхгүй байсан үг хэллэг орж ирэх болжээ. Монгол хэлний өдөр тутмын хэрэгцээний үгсийн бүтцийг үлгэрлэвэл Батын гэдэг монгол айлд гэрээр дүүрэн, англи, орос, солонгос хүмүүс суугаад өөр өөрийн хэлээр ярилцах мэт санагдана. Тэгээд наанадаж мянга гаруй жилийн түүхтэй босоо монгол

бичгээ зарим хүмүүс өөнтөглөн орхих арга сүвэгчлэн байх шиг. Гадаад үгийг монголчлон нутагшуулах олон арга байдгийн нэг нь хуучин байсан үгийг шинэ утгаар хэрэглэх. Нэг жишээ, “**удирдлага**” гэдэг нэг суваг буюу хөтөлбөрөөс нөгөөд шилжүүлэх хэрэгсэл болж шинэ утгатай боллоо. “**Гар**” гэдэг гар утасны товч нэр болох жишээтэй. Энерги “**эрчис**” болох жишээтэй. Зарим гадаад үг анх орж ирсэн шигээ гэнэт алга болох нь цөөнгүй. Нэг үе манай үгсийн сангийн их өргөөний хойморт тухтай нь аргагүй завилаад суучихсан байсан “**молоко**”, “**колбаса**”, “**билет**”, “**контор**” гэх үгсүүд ирсэн шигээ хурдан эргэн оджээ. Харин түүний оронд “**менежер**” бүр “**оффис**”-тойгоо орж ирээд “**менежмент**”-ээ эрхэлж байх жишээтэй. Бас хэдэн аравны турш анх яаманд заларч байснаа сүүлд өрөө түрээслэн сууж байсан “**ксерокс**” –ыг “**канон**” сэжин гаргаад одоо “**хувилагч**”-тай ана мана үзэлцэж байна.

2.3. Эсрэгээр гадаадын зохиол, эхийг эх хэлэндээ орчуулахдаа бас л тэр зүйлийг тун мэддэг байж орчуулах хэрэгтэй болж таарах нь. Нэг үгийн олон утга энд чухам ямар утгаараа орж гэдгийг ялгаж салгах нэгд чухал, бас монгол аху-д байдаггүй зүйлийг орчуулах уу, тайлбарлах уу? гэсэн асуудал үүдэн гарч буй нь тодорхой.

Нэр томъёо үүсэх зарчмын тухай:

- Үгийн сан дахь түүхэн ба хуучирсан үгийг шинэ утгаар сэргээн ашиглах: **удирдлага, гар**
- Үг бүтэх аргуудыг ашиглан шинэ нэр томъёо бий болгох: **түгээгүүр, дамжуулга**
- Нутгийн олон аялгууны үгнүүдээс оновчтой заримыг нь авч нэр томъёоны агуулгатай болгож хэрэглэх: **долмаач**
- Гадаад хэлний болон олон улсын чанартай нэр томъёог хуулбарлан орчуулах: **Television-телевизер**

Эдгээр зарчмын аль оновчтойгоор нь тухайлан авсан гадаадын нэр томъёог монгол хэлэнд нутагшуулах буюу монгол шинэ нэр томъёо араажав, гарааш гэх мэт үүсгэнэ.

Гадаадын нэр томъёог монгол хэлнээ үгчлэн орчуулах, эс бүтвээс утгачлан орчуулах, ижил утгатай зүйлээр дүйцүүлэх, ижил төрлийн юмаар дүйцүүлэх олон янзын арга байдаг байна.

2.4. Хэлмэрчлэхэд анхаарах зүйл

Хэлмэрч хүн **сонсох, цээжлэх, хөрвүүлэх, ярих** ийм дөрвөн зүйлийг зэрэг хийдэг онцлогтой. Ялангуяа М.Горбачев, Р.Гончигдорж шиг үргэлжлүүлэн зай завсар өгөхгүй ярьдаг хүний яриаг хам орчуулах бол туйлын бэрх ажил бөгөөд зөвхөн туршлагажиж, дадлагажсан хэлмэрчийн л дөнгөх ажил. Эхний ярьсныг хэлмэрчилж байх явцдаа дараагийн яриаг цээжилж, хөрвүүлэх бэлтгэл хийж байх болно. Хэрвээ ярьж байгаа хүн аливаа зохиол, бүтээлээс ишлэл авах, зүйр цэцэн үг хэлэх аваас тэр бүхнийг мэдэж байх шаардлагатай, мэдэхгүй үг хэллэг хэрэглэх аваас яах вэ гэдэг

асуудал тулгарна. Яригчийн яриаг хам **цагаар хэлмэрчлэх** боловч яригчтай шууд харьцаж, лавлаж асуух боломжгүй байдаг онцлогтой.

Хам хэлмэрчлэхэд ихэнхдээ хэлмэрч тусгай кабинд суугаад индэрт үг хэлж байгаа хүний яриаг хэлмэрчлэх жишээтэй. Хам хэлмэрч тухайн хүний урьд өмнө хэлж байсан үг, ярилцлагыг түүний уншиж судлах, хэлмэрчлэх дадлага хийх, хэлэх гэж байгаа үг, хийх ярианы сэдвийг урьдчилж мэдээд бэлтгэж болох талтай.

2.5. Орчуулахад анхаарах зүйл

Алив яруу найраг шүлгийг орчуулахдаа **“яруу найртай, утга төгс, мэдэхүйеэ хялбар”** хэмээх гурван зарчмыг чанд баримтлах ёстойг дурдсан нь олон.

“Орчуулагч, хэлмэрч нар ашиг хийгээд алдрыг хүсэх, алагчлахуй сэтгэлийг тэвчиж, шударга оюунаар уг утгасын хувийг сайтар шинжлээд, өөрийн ... эс мэдснээ, мэргэн хэмээн алдаршсан дээд доод хэнээс ч болов сайтар асууж, сэжгийг таслаад, тодорхой бөгөөд мэдэхүйеэ хялбар үгээр утга лугаа үл харшилдуулан сайтар орчуулбаас өөр бусдын үндсэнд олон сайн чуулганыг ариутган чадах...”⁹

“...Нэгэн нэр олон утганд орох нугуудыг нь урьд хойдыг сайтар шинжлээд нэгэнтээ шийдэж болох бөгөөс алинд хүртэх түүнд орчуул...”¹⁰,

“Шүлгийг орчуулах гэгч үг, утгыг орчуулах төдий биш, түүний найруулгыг хэв журам ба уран хэл, сэтгэлийг хөдөлгөх чадлыг бүрнээ орчуулах хэрэгтэй”¹¹ гэжээ.

3. “Ертөнцийн гурав”-ыг орчуулах зарим нэг оролдлого:

3.1. Ертөнцийн гурван хачин

Алгандаа хөхтэй араатны хаан арслан нэг хачин
Амаа байтал шилээрээ дугардаг голио нэг хачин
Амрагын дээд аав, ээж хоёр золгодоггүй нэг хачин

Эхний оролдлого:

Эхний удаад өгүүлбэрийн гишүүнийг тодотгон утга санааг орхилгүй гаргахын тулд үгчлэн орчуулахыг хичээв.

⁹ “Мэргэд гарахын орон” үндэсний хэвлэлийн хороо, Бээжин, 1988. 70-73 –р тал

¹⁰ “Мэргэд гарахын орон” үндэсний хэвлэлийн хороо, Бээжин, 1988. 75--78 –р тал

¹¹ Ц.Дамдинсүрэн, Монгол хэл бичгийн тухай, Улаанбаатар, 1957, 10-р тал

Es ist verwunderlich, dass der Lцwe, der Kцnig der Raubtiere, seine Zitzen auf der FuЯsohle hat.

Es ist verwunderlich, dass die Grille, trotz Vorhanden sein des Mundes, durch den Nacken zwitschert.

Es ist verwunderlich, dass die Eltern, die das hцhste Stadium der Liebe erreicht haben, zum Neuen Jahr miteinander keine BegрьЯungszерemonie machen.

Утга санаа нь ерөнхийдөө гарсан боловч нэгд монгол эхээсээ дэндүү урт болов. Хоёрт герман шүлгийн сүүл холбох зарчим хийгээд өргөлтийг харваас баримталж чадсангүй.

Хоёр дахь оролдлого:

Өгүүлбэрийн бүтцийг өөрчлөн хоёр өгүүлбэрээр илэрхийлэхдээ эхнийхийг туслах, хоёр дахийг гол үгүүлбэрээр илэрхийлэхийг оролдлоо.

Dass der Raubtierkцnig Lцwe seine Zitzen auf seinen FuЯsohle hat, ist **verwunderlich**,

Dass die Grille trotz vorhanden seines Mundes durch den Nacken zwitschert, ist **verwunderlich**,

Dass das hцhste Liebespaar Eltern zum Neuen Jahr keine BegрьЯung macht, ist **verwunderlich**.

Нэгд нэг мөрөн дэх үгийн тоо эрхбиш цөөрсөн, хоёрт герман шүлгийн хэмнэл, өргөлт харваас дээрдэж, уншихад хялбар болсон.

3.2. “Ертөнцийн гурван хөнгөн”- ийг орчуулах оролдлого

Урсахаас ус нэг хөнгөн

Хийсэхээс өд нэг хөнгөн

Өргөхөд өвс нэг хөнгөн

Эхний оролдлого

Эхлээд утга санааг бүрэн гаргах үүднээс утгачлан орчуулахыг хичээв.

Die drei Leichten der Welt

Von den FlieЯenden ist das Wasser leicht zu bewegen.

Von den Wind Forttreibenden ist die Feder leicht zu fliegen.

(Von den Windigen ist die Feder leicht fortzutragen.)

Von den Voluminцsen ist das Heu leicht zu tragen.

Герман найруулга тааруухан, шүлэглэлт барагтайхан болсон шиг санагдана.

Хоёр дахь оролдлого

Үг бүрийг утгачлан аваад хөнгөн маягаар орчуулахыг хичээв.

Die drei Leichten der Welt

Von den FlieЯenden ist das Wasser leicht,

Von den Wind Forttreibenden ist die Feder leicht,

Von den Voluminцsen ist das Heu leicht.

Бүр ахиулаад арай цомхон бүтэцтэй болгохыг хичээлээ.

Die drei Leichten der Welt

FlieЯendes Wasser ist leicht.

fliegendes Feder ist leicht.

Getrocknetes Gras ist leicht.

Миний бодлоор шүлэглэлт гайгүй, уншихад амархан, цээжлэхэд хялбар болсон шиг.

3.3. “Ертөнцийн гурван улаан”-ыг орчуулах оролдлого

Ертөнцийн гурван улаан

Жавартай тэнгэрийн хаяа нэг улаан

Жаргалтай хатны хацар нэг улаан

Жартгай хүний нүд нэг улаан

Эхний оролдлого:

Гол нь утга санааг аль болох бүрэн гаргахыг хичээв.

Die drei Roten der Welt

Wenn das Wetter kalt ist, ist einmal der Horizont beim Sonnenuntergang rot.

Wenn die Frau glücklich ist, strahlen einmal ihre Wangen rot.

Wenn ein Mensch mьde ist, sind einmal seine Augen rot.

Өгүүлбэрийн бүтэц жигд бус, бөгөөд туслах болон үндсэн өгүүлбэрээр илэрхийлсэн билээ.

Хоёр дахь оролдлого:

Die drei Leichten der Welt

Der Horizont des kalten Wetters ist rot,

Die Wangen glücklichler Frau sind rot,

Die Augen des mьden Mannes sind rot.

Бүтэц нь эхтэйгээ төстөйтөр, шүлэглэлт дажгүй, уншихад хялбар болжээ.

3.4.Ертөнцийн гурвыг орчуулахад гарч болох бэрхшээл:

1. Хуучирсан нэр томъёог зөв ойлгож орчуулах
2. Монгол хэлэнд нэг үгээр илэрхийлэх боловч олон янзаар орчуулагдах,
3. Монгол хэлэнд жирийн тодотгол гишүүнтэй өгүүлбэрийг герман хэлэнд тодотгол өгүүлбэрээр илэрхийлэх тал байдаг.
4. Герман шүлэгний аясаар орчуулахад төвөгтэй,
5. Угаас харийн хэлэнд, тэр дундаа шүлэг орчуулах төвөгтэй.

Дүгнэлт:

1. “Ерөнцийн гурав”-ыг орчуулахад нэгдүгээрт эх сэдвээ өөрөө бүрэн ойлгох, хоёрт орчуулахдаа утга санааг зөв, нэг мөр гаргахыг гол болгох, гуравт эх хэлээрээ уншиж байгаа хүнд аль болох ойлгомжтой, энгийн үг, өгүүлбэрээр илэрхийлсэн байх ёстой мэт санагдана.
2. Бүтцийн хувьд эхээс хэт урт, бас богино биш байхаас гадна, ардын аман зохиол гэдэг нь харагдаж байх, өөрөөр хэлбэл уншихад амар, цээжлэхэд хялбар байвал зохилтой.
3. “Ерөнцийн гурав”-ыг яруу найргийн хэлбэрээр бичсэн байдгийг анхаарч орчуулахдаа тэр хэлбэрийг нь гаргахыг хичээх, тэгэхийн тулд үгийн олон утгыг сайн мэдэх **ижил** болон **эсрэг** утгатай үгсийг сайн эзэмшсэн байх шаардлагатай мэт санагдлаа.
4. Хэдийгээр “ертөнцийн гурав”-ыг орчуулах гэдэг дурын хүний барьж аван хийх гарын дорхи ажил биш ч гэлээ, хэн нэг нь зориглон эхлэх хэрэгтэй. Шүүмжлэх, засах, санаа өгөх хүн гарч л таараа. Шүүмжлэлийн дагуу шантралгүй, мохолгүй, оролдоод байх хэрэгтэй. Оролдлого ихэт оройд нь гарна гэсэн мэргэн үг ч байдаг. “*Bbung macht den Meister!*”

Ашигласан ном:

1. Г.Аким Монгол өвөрмөц хэлцийн тайлбар толь
2. Монгол хэлний хэлц үгийн сан
3. Ардын аман зохиол, ертөнцийн гурав

Хавсралт:

Ертөнцийн гурав

Die Dreien der Welt

Ертөнцийн гурван цагаан

Die drei Weißen der Welt

Өсөхөд шүд нэг цагаан

Beim Aufwachsen sind die Zähne weiß,

Өглөхөд үс нэг цагаан

Beim Alt werden sind die Haare weiß,

Үхсэн хойно яс нэг цагаан

Nach dem Sterben sind die Knochen weiß.

Ертөнцийн гурван цэгц

Die drei Ordentlichen der Welt

Сая буусан бэр нэг цэгц

Die neu aufgestellte Jurte ist einmal ordentlich.

Нуурт суусан нугас нэг цэгц

Die Schwäne im See sind einmal ordentlich.

Хүлэг морины дэл нэг цэгц

Die Mähne des Pferdes ist einmal ordentlich.

Ертөнцийн гурван цэмцгэр

Die drei Akkuraten der Welt

Үүлээ хөөсөн тэнгэр нэг цэмцгэр

Der wolkenlose Himmel ist einmal akkurat.

Үнсээ гаргасан тулга нэг цэмцгэр

Die Feuerstelle, deren Asche gerade entfernt wurde, ist einmal

Үсээ самнасан авгай нэг цэмцгэр akkurat.
Die Frau, die beim Friseur war, ist einmal akkurat.

Ертөнцийн гурван цэнхэр Die drei Blauen der Welt
Холоос харагдаж байгаа уул нэг Die Berge in der Ferne sind einmal blau.
цэнхэр Das Wasser in der Tiefe ist einmal blau.
Хонхорт байгаа ус нэг цэнхэр Der Himmel der Erde ist einmal blau.
Хорвоод байгаа тэнгэр нэг цэнхэр

Ертөнцийн гурван чимэг Die drei Schmuckstücke der Welt
Сайхан хүүхэн гэрийн чимэг Eine schöne Frau ist der Schmuck des Hauses.
Сайн морь эрийн чимэг Ein schönes Pferd ist der Schmuck des Reiters.
Сагсар мод уулын чимэг Die prachtvollen Bäume sind Schmuck des Berges.

Ертөнцийн гурван чимэг Die drei Schmückenden der Welt
Тэмээ говийн чимэг Die Kamele schmücken die Wüste.
Тэрэг хотын чимэг Die Autos schmücken die Stadt.
Сахал эрийн чимэг Der Bart schmückt den Mann.

Ертөнцийн гурван цоорхой Die drei Undichten der Welt
Орох тэнгэрийн орой цоорхой Beim Dauerregen ist der Himmel oben undicht.
Орсон буурын шил ноорхой Dem brunftigen Kamelhengst ist der Nacken undicht.
Ой болоогүй хүүхдийн зулай Dem neugeborenen kleinen Baby ist die Stirn undicht.
цоорхой

Ертөнцийн гурван шар Die drei Gelben der Welt
Эрдэнэд алт нэг шар Unter den Juwelen ist einmal das Gold gelb.
Эдэнд жанч нэг шар Unter den Bekleidungen ist einmal der Umhang¹³ gelb.
Идээнд уураг¹² нэг шар Unter den Speisen ist einmal die Erstmilch gelb.

Ертөнцийн гурван шарвагануур Die drei Lieb dienenden der Welt
Хоол горьдсон хав шарвагануур Die Welpе, die etwas pressen möchte, ist liebdienend¹⁴.
Хов горьдсон хутгагч шарвагануур Der Neugieriger, der etwas hören möchte, ist liebdienend.
Хувь горьдсон бялдууч Der Heuchler, der etwas haben möchte, ist liebdienend¹⁵.
шарвагануур

¹² Гал уураг шар байдаг

¹³ Der Umhang eines Lamas

¹⁴ Wedelnd,

¹⁵ heuchlerisch

Ертөнцийн гурван ширүүн

Төрд элч ширүүн
Төмөрт хуурай ширүүн
Төхөмд зараа ширүүн

Die drei Rauen¹⁶ der Welt

Der Bote des Staats ist rau.
Der Raspel des Eisens ist rau,
Der Igel in der Schlucht ist rau.

Ертөнцийн гурван шившиг

Аманцар морь авын шившиг
Аальгүй авгай гэрийн шившиг
Хэрүүлч хүн хээрийн шившиг

Die drei Blamagen der Welt

Das eigenwillige Pferd ist bei der Jagd eine Blamage.
Die kokette Frau ist zu Hause eine Blamage.
Der/Die Streitsüchtige ist auf der Reise eine Blamage.

Ертөнцийн гурван шившиг

Муу эмээл морины шившиг
Муу эм гэрийн шившиг
Муу нохой хотны шившиг

Die drei Schdndenden der Welt

Ein hdsslicher Sattel schdndet das Pferd.
Eine schlechte Frau schdndet die Нтт’.
Ein schlechter Hund schdndet die Ньрд’.

Ертөнцийн гурван янаг

Баян хүнд худалдаачин янаг
Бааран хүнд нохой янаг
Ховч хүнд ноён янаг

Die drei Lieben der Welt

Dem Reichen ist der Hdndler lieb.
Dem Hockenden ist der Hund lieb.
Den Schwdtzern ist der Kцnig lieb.

Ертөнцийн гурван яншаа

Хөдлөхгүй төхник хашааны яншаа
Хүмүүжилгүй хүн хөгжлийн яншаа
Хүнд сурталтан нийгмийн яншаа

Die drei Sturenden der Welt

Ein kaputtes Auto stцrt im Hof die Bewegung.
Ein unerzogener Mensch stцrt die Entwicklung.
Ein Вьрократ stцrt die Gesellschaftshaltung.

Ертөнцийн гурван хачин

Алгандаа хөхтэй арслан нэг хачин
Амаа байтал шилээрээ дугардаг
голио нэг хачин
Амрагын дээд аав, ээж хоёр
золгодоггүй нэг хачин

Die drei Wunderlichen der Welt

Dass der Raubtierкцnig Lцwe seine Zitzen auf seinen FuЯsohle hat,
ist verwunderlich,
Dass die Grille trotz vorhanden seines Mundes durch den Nacken
zwitschert, ist verwunderlich,
Dass das hцchste Liebespaar Eltern zum Neuen Jahr keine
BegрьЯung macht, ist verwunderlich.

Мэлхийн мээм (хөх) нүдэндээ
байдаг нэг хачин
Аалзны мээм нуруундаа байдаг нэг
хачин

Die drei Wunderlichen der Welt

Es ist verwunderlich, dass der Frosch seine Zitzen an den Augen hat.
Es ist verwunderlich, dass die Spinne ihre Zitzen auf dem Rьcken
hat.
Es ist verwunderlich, dass der Elefant seine Zitzen auf der FuЯsohle

¹⁶ Ширүүн – wutschnaubend, , rau, stachelig

Зааны мээм тавгандаа байдаг нэг хачин hat.

Ертөнцийн гурван ширүүн

Хөгширсөн үхрийн хэл нэг ширүүн
Хаднаас гарсан хайрга нэг ширүүн
Хааны тогтоосон хууль нэг ширүүн

Die drei Rauhen der Welt

Die Zunge einer alten Kuh ist rau.
Der Kies der Granite ist rau.
Die Gesetze des Königs sind rau.

Ертөнцийн гурван яншаа

Хасаг тэрэг замын яншаа
Хатсан ховоо худгийн яншаа
Хөгшин нохой хотны яншаа

Die drei Murrischen der Welt

Der Karren auf der Straße ist murrisch.
Der trockene Schopfbeutel im Brunnen ist murrisch.
Der alte Hund vor der Herde ist murrisch.

Ертөнцийн гурван ногоон

Усанд замаг нэг ногоон
Хаданд хөгц нэг ногоон
Дэлхийд ногоо нэг ногоон

Die drei Grünen der Welt

Einmal ist der Tang im Wasser grün.
Einmal ist die Flechte auf dem Felsen grün.
Einmal sind die Pflanzen auf der Erde grün.

Тагт ургасан арц нэг ногоон
Тайгад ургасан хуш нэг ногоон
Талд ургасан зээргэнэ нэг ногоон

Die drei Immergrünen der Welt

In den Bergen ist einmal der Wacholder grün.
Im Wald ist einmal die Kiefer grün.
In der Steppe ist einmal der Ephedra grün.

Ертөнцийн гурван улаан

Жавартай тэнгэрийн хаяа нэг улаан
Жаргалтай хатны хацар нэг улаан
Жартгай хүний нүд нэг улаан

Die drei Roten der Welt

Wenn das Wetter kalt ist, ist einmal der Horizont beim Sonnenuntergang rot.
Wenn die Frau glücklich ist, strahlen einmal ihre Wangen rot.
Wenn ein Mensch müde ist, sind einmal seine Augen rot.

Жалганд ургасан сухай нэг улаан
Жаварт гүйсэн үнэг нэг улаан
Зуудаг нохойн жавьж нэг улаан

Die drei Roten der Welt

Einmal ist die Tamariske in der Schlucht rot.
Einmal ist der in der Kälte geborene Fuchs rot.
Einmal ist der Mund des bissigen Hundes rot.

Ертөнцийн гурван хөх

Уудам дэлхийн тэнгэр нэг хөх
Унтрах галын дөл нэг хөх
Урсах голын ус нэг хөх

Die drei Blauen der Welt

Einmal ist der Himmel über der weiten Erde blau.
Einmal ist die Flamme des erlöschenden Feuers blau.
Einmal ist das Wasser des fließenden Flusses blau.

Ертөнцийн гурван хар

Цасанд мөр нэг хар
Цаасанд бичиг нэг хар

Die drei Schwarzen der Welt

Auf dem Schnee sind die Spuren schwarz.
Auf dem Papier sind die Schriften schwarz.

Зарганд үг нэг хар

Bei der Klage sind die Worte schwarz.

Ертөнцийн гурван хар

Тостойгоос тогоо нэг хар
Билэгтэйгээс бичиг нэг хар
Амттайгаас архи нэг хар

Die drei Schwarzen der Welt

Von den Fettigen ist einmal der Kochkessel schwarz.
Von den Geistigen ist einmal die Schrift schwarz.
Von den Schmeckenden ist einmal der Schnaps schwarz.

Ертөнцийн гурван хар

Айраг цагаанаас гарч байвч архи нэг хар
Арчиж зүлгэж байвч тогоо нэг хар
Алт мөнгөөр чимэж байвч үс нэг хар

Die drei Schwarzen der Welt

Obwohl er von Joghurt abstammt, ist der Brandwein einmal schwarz.
Obwohl (er) ständig geputzt und abgetrocknet (wird), ist einmal der Kochkessel schwarz.
Obwohl sie mit Gold und Silber geschmückt werden, sind einmal die Haare schwarz.

Ертөнцийн гурван харанхуй¹⁷

Эрдэмгүй хүн харанхуй
Саргүй шөнө харанхуй
Хоньгүй хот харанхуй

Die drei Dunkeln der Welt

Der Geist der Ungebildeten ist dunkel.
Die Neumondnacht ist dunkel.
Die Viehstelle ohne Schafe ist dunkel.

Ертөнцийн гурван сайхан

Зөөж буухад зүлэг сайхан
Зөвлөж ярихад аав сайхан
Эргүүлж мөлжихөд хүзүү сайхан

Die drei Schönen der Welt

Für den Umzug ist das Weideland schön.
Für die Ratsuchenden ist der Vater schön.
Mit vielen Spalten ist der Halswirbel schön.

Ертөнцийн гурван сайхан

Арван тавны сар нэг сайхан
Атар газрын цэцэг нэг сайхан
Аав, ээжийн сургааль нэг сайхан

Die drei Schönen der Welt

Einmal ist der Vollmond am Himmel prachtvoll.
Einmal sind die Blumen der Wiese prachtvoll.
Einmal sind die Lehren der Eltern prachtvoll.

Ертөнцийн гурван сайхан

Аваагүй байхад авгай сайхан
Алаагүй байхад үнэг сайхан
Амсаагүй байхад архи сайхан

Vor dem ist ... schön

Vor dem Heiraten ist die Frau verführerisch schön.
Vor dem Jagen ist der Fuchs (ver)lockend schön.
Vor dem Trinken ist der Schnaps anziehend schön.

Ертөнцийн гурван хайраан

Учир мэдэхгүй хүнд үг хайран
Үнэр мэдэхгүй хүнд зандан хайран

Die drei Schaden der Welt

Dem den Sinn nicht Verstehenden ist das nützliche Wort zu schade.
Dem den Duft nicht Unterscheidenden ist das Sandelholz zu schade.

¹⁷ Dumm, stockfinster, schwarz,

Үзээд мэдэхгүй хүнд эд хайран

Ертөнцийн гурван баян

Эрдэм ном дээд баян

Үр хүүхэд дунд баян

Эд хөрөнгө адгийн баян

Dem die Qualitdt nicht Erkennenden ist die gute Sache zu schade.

Die drei Reichen der Welt

Das Wissen ist der beste Reichtum.

Die Kinder sind der mittlere Reichtum.

Die Habseligkeiten sind der schlechteste Reichtum.

Ертөнцийн гурван баян

Газар үндсээр баян

Тэнгэр одоор баян

Далай усаар баян

Die drei Reichen der Welt

Die Erde ist an Wurzeln reich.

Der Himmel ist an Sternen reich.

Der Ozean ist an Wasser reich.

Ертөнцийн гурван хоосон

Барьж тавьж байвч зүүд хоосон,

Барай торойж байвч зэрэглээ
хоосон

Бархирч архирч байвч цуурай нэг
хоосон

Die drei Leeren der Welt

Obwohl es man mit der Hand anfasst, ist der Traum leer.

Obwohl man wahrhaftig sieht, ist die Fata Morgana leer.

Obwohl man wirklich hört, ist das Echo leer.

Ертөнцийн гурван худал

Тэхийн эвэр тэнгэрт хүрнэ гэдэг
нэг худал,

Тэмээн сүүл газарт хүрнэ гэдэг нэг
худал

Тэнэг хүн ноён сууна гэдэг нэг
худал

Die drei Unwahren der Welt

Dass die Hцrner des Steinbocks den Himmel erreichen, ist einmal
unwahr.

Dass der Kamelschwanz die Erde berцhrt, ist einmal unwahr.

Dass der Idiot den Thron des Kцnigs besteigt, ist einmal unwahr.

Ертөнцийн гурван хөнгөн

Урсахаас ус нэг хөнгөн

Хийсэхээс өд нэг хөнгөн

Өргөхөд өвс нэг хөнгөн

Die drei Leichten der Welt

Von den FlieЯenden ist das Wasser leicht zu bewegen.

Von den Wind Forttreibenden ist die Feder leicht zu fliegen.

(Von den Windigen ist die Feder leicht fortzutragen.)

Von den Voluminцsen ist das Heu leicht zu tragen.

Ертөнцийн гурван муухай

Булган малгайд чихэвч муухай

Хувхай эмээлэнд хударга муухай

Үүний хүнд ууц муухай

Die drei Hdsslichen der Welt

Die Ohrenklappe einer Zobelmцtze ist hdsslich.

Der Schwanzriemen eines farblosen Sattels ist hdsslich.

Фьr den an der Тьr Stehenden ist der Feststeller hdsslich.

Ертөнцийн гурван ариун

Ургаж байгаа арц нэг ариун

Уугьж байгаа хүж нэг ариун

Урсаж байгаа ус нэг ариун

Die drei Reinen der Welt

Der wachsende Wacholder ist rein.

Die brennende Duftstange ist rein.

Das Wasser des flieЯenden Flusses ist rein.

Ертөнцийн гурван их санаатан

Голио үер ирэхийг болгоомжлон
өндөрт гарч зогсоно,
Тогоруу дэлхий цөмрөхийг
болгоомжлон сэм сэм алхана
Мэлхий тэнгэр унахыг
болгоомжлон дээшээ харж хэвтэнэ.

Die drei Ibbervorsichtigen der Welt

Die Grille steht auf einer Höhe, um sich vor der Ibberschwemmung zu retten.
Die Kraniche gehen vorsichtig, um nicht die Erde einstürzen zu lassen.
Die Frösche schlafen auf dem Rücken, um, falls der Himmel einstürzt, ihn zu stützen.

Ертөнцийн гурван хурц

Үхэх хүний нүд нэг хурц
Үгүйрэх хүний шүд нэг хурц
Үүлэн чөлөөний нар нэг хурц

Die drei Scharfen der Welt

Vor dem Sterben sind die Augen scharf.
Die Zähne der verarmenden Menschen sind scharf.
Die Sonne in der Wolkenlocke ist scharf.

Ертөнцийн гурван гүн

Их далайн ероол нэг гүн
Эрдэмтэн хүний санаа нэг гүн
Энх төрийн бодлого нэг гүн

Die drei Tiefen der Welt

Der Boden des großen Ozeans ist tief.
Die Gedanken der Gelehrten sind tief.
Die Politik eines friedlichen Staates ist tief.

Ертөнцийн гурван тус

Төрөхөд халамжлахын тус
Өвдөхөд сувилахын тус
Үхэхэд яс барихын тус

Die drei Hilfen der Welt

Die Fürsorge beim Aufwachsen ist eine Hilfe.
Die Pflege des Kranken ist eine Hilfe.
Die Bestattung des Toten ist eine Hilfe.

Ертөнцийн гурван ганцаараа

Сал онгоцноос салбал далайд
дунд ганцаараа
Саадаг нумнаас салбал дайсны
дунд ганцаараа
Сайн мориноос салбал талын дунд
ганцаараа

Die Verlassenen der Welt

Wenn man sich vom Schiff oder Boot trennt, ist man im Meer verlassen.
Wenn man sich von den Pfeil und Bogen trennt, ist man unter den Feinden verlassen.
Wenn man sich vom besten Ross trennt, ist man in der Steppe verlassen.

Ертөнцийн гурван олон

Худалч хүний нээрээн олон
Хуурамч хүний хөөрхий олон
Хуудуу хүний за олон

Die drei oft Sagenden der Welt

Der Lügner sagt oft wirklich.
Der Schmeichler sagt oft Liebling.
Der Nichtstuer sagt oft ja.

Ертөнцийн гурван бардам

Хад сайтын үнэг бардам
Хадам сайтын хүргэн бардам
Нохой сайтын хот бардам

Die drei Prahlerischen der Welt

Der Fuchs, der viele versteckte Winkel hat, ist prahlerisch.
Der Schwiegersohn, der gute Schwiegereltern hat, ist prahlerisch.
Die Herde der Familie, die einen guten Hirtenhund hat, ist

prahlerisch.

Ертөнцийн гурван дөт

Сарны гэрэлд нар дөт
Насны туршид хань дөт
Ноёны хэрэгт боол дөт

Die drei Nahen der Welt

Dem Vollmond ist die Sonne nah.
Für das Leben ist die/der Gefährte nah.
Für die Arbeit eines Königs ist der Untertan nah.

Ертөнцийн гурван тансаг

Агаарт байдгаас сар тансаг,
Дэлхийд байдгаас цэцэг тансаг
Дэлхийд байдгаас арслан тансаг

Die drei Prächtigen der Welt

Der Vollmond am Himmel ist prächtig.
Die Blumen in der Steppe sind prächtig.
Der Löwe unter den Raubtieren ist prächtig.

Ертөнцийн гурван хурдан

Салхитай тэнгэрийн үүл нэг
хурдан
Саруул ухаантны санах нэг хурдан
Сайн морины давхих нэг хурдан

Die drei Schnellen der Welt

Die Wolken am Himmel beim Wind sind schnell.
Das Denken des Intelligenzen ist schnell.
Das Rennen eines guten Pferdes ist schnell.

Ертөнцийн гурван бэрх

Замгүй давааг давахад бэрх
Зангилсан үгийг тайлахад бэрх
Зааны соёог залахад бэрх

Die drei Schwierigkeiten der Welt

Das Überqueren eines spurlosen Passes ist schwer.
Das Verstehen eines verschlüsselten Wortes ist schwer.
Das Geradebiegen des Elfenbeins ist schwer.

Ертөнцийн гурван бэрх

Чулуун дээр ногоо ургуулах нэг
бэрх
Усан дээр гал түлэх нэг бэрх
Үхрийн эвэр дээр цас тогтоох нэг
бэрх

Die drei Schweren der Welt

Auf dem Stein etwas anpflanzen, ist schwer.
Auf dem Wasser Feuer machen, ist schwer.
Auf dem Ochsenhorn den Schnee befestigen, ist schwer.

Ертөнцийн гурван хэцүү

Үерлэн шуугих нь ус хэцүү
Дүрэлзэн асах нь түймэр хэцүү
Эрчлэн хийсэх нь салхи хэцүү

Die drei Mächtigen der Welt

Das Wasser als Überschwemmung ist mächtig.
Das Feuer als Brandverbreitung ist mächtig.
Der Wind als Wirbelsturm ist mächtig.

Ертөнцийн гурван хэцүү

Тоолоход од хэцүү
Туулахад тал хэцүү
Туухад гахай хэцүү

Die drei Schwierigen der Welt

Das Zählen der Sterne ist schwierig.
Das Überqueren der weiten Steppe ist schwierig.
Das Treiben der Schweine ist schwierig.

Ертөнцийн гурван зовдог

Үхэр туусан хүн хүрэн хүртлээ
зовдог
Үр муут хүн үхэн үхэтлээ зовдог
Үндэс муут мод унанунатлаа
зовдог

Die drei sich Quhlenden der Welt

Der Kuhlreiber quhlt sich bis zum Zielort.
Der seine Kinder schlecht erzogen hat, quhlt sich bis zum Tod.
Der Baum, der schlechte Wurzeln hat, quhlt sich bis zum
Umstürzen.

Ертөнцийн гурван гадна

Харьд очдогоороо хүүхэн гадна
Хал үздэгээрээ гар гадвна
Хар нүднээс хөмсөг гадна

Die drei drauЯen Bleibenden der Welt

Die Frau, die als Braut geht, ist drauЯen.
Die schwer arbeitenden Hdnde sind drauЯen.
Die Augenbrauen sind drauЯen.

Ертөнцийн гурван буг

Харамч эм гэрийн буг
Хавтгай түлээ галын буг
Хатсан ховоо худгийн буг

Die drei Ddmonen der Welt

Die geizige Frau ist im Haus ein Ddmon.
Das flache Holz ist im Ofen ein Ddmon.
Der getrocknete Howoo¹⁸ ist im Brunnen ein Ddmon.

Ертөцийн гурван өшөөтэй

Үнэн үг хэлсэн хүнд хүн өшөөтэй
Үхэр унасан хүнд нохой өшөөтэй
Улаа хийсэн газарт үхэр өшөөтэй

Die drei Hassenden

Der, die Wahrheit sagt, wird von den Menschen gehasst,
Der, die Kuh reitet, wird vom Hund gehetzt.
Die Viehschlachtstelle wird von der Kuh gehasst.

Ертөнцийн гурван давхаргатай

Өндөр тэнгэр үүлэн давхаргатай
Өвсөн дэлхий цасан давхаргатай
Өргөн далай мөсөн давхаргатай

Die drei Schichten der Welt

Der hohe Himmel hat eine Wolkenschicht.
Die Pflanzenerde hat eine Schneeschicht.
Der groЯe See hat eine Eisschicht.

Ертөнцийн гурван даардаггүй

Ууланд төрсөн бүргэд даардаггүй
Усанд төрсөн загас даардаггүй
Ургацанд төрсөн уйгур даардаггүй

Die drei nicht Frierenden der Welt

Der im Gebirge geborene Adler friert nicht.
Der im Wasser geborene Fisch friert nicht.
Der im Stangenzelt geborene Uigur friert nicht.

Ертөнцийн гурван үгүй

Худгийн усанд загас үгүй
Хууч үгэнд худал үгүй
Хөндий тэнгэрт багана үгүй.

Die drei Keinen der Welt

Das Brunnenwasser enthдlt keinen Fisch.
Die alten Worte enthalten keine Unwahrheit.
Der leere Himmel hat keine Stütze.

Ертөнцийн гурван тэнэг

Die drei Idioten der Welt

¹⁸ der Schupfeimer, frьher hat man ihn aus Leder gemacht.

Эрхэм тэнэг морио магтана
Дунд тэнэг эхнэрээ магтана
Адгийн тэнэг биеэ магтана

Sein Pferd lobt der einfache Idiot.
Seine Frau lobt der mittlere Idiot.
Sich selbst lobt der letzte Idiot.

Ертөнцийн гурван муруй

Урсгал ус нэг муруй
Ургаа мод нэг муруй
Урт зам нэг муруй

Die drei Krümmen der Welt

Das Wasser im Fluss ist krumm.
Der wachsende Baum ist krumm.
Der weite Weg ist krumm.

Ертөнцийн гурван дутуу

Ууланд бүслүүргүй нэг дутуу
Далай таглаагүй нэг дутуу
Тэнгэр баганагүй нэг дутуу

Die drei Fehlenden der Welt

Dem Berg fehlt der Gürtel einmal.
Dem Ozean fehlt der Deckel einmal.
Dem Himmel fehlt die Stütze einmal.

Ертөнцийн гурван хагас

Унтах гэдэг үхэхийн хагас
Унгах баахын хагас
Уурлах гэдэг галзуурахын хагас

Die drei Hälften der Welt

Das Schlafen ist die Hälfte des Sterbens.
Das Aufblühen ist die Hälfte des Scheiterns.
Das Dürren ist die Hälfte des tollwütigen Werdens.

Ертөнцийн гурван хол

Үхэр унасан хүнд газар хол
Үхсэн хүнд дэр хол
Үгүйрсэн хүнд юм хол

Die drei Weiten der Welt

Für den Ochsenreiter ist der Weg weit.
Für den Toten ist das Kopfkissen weit.
Für den Verarmten ist das Eigentum weit.

Ертөнцийн гурван цоорхой

Орох тэнгэрийн орой цоорхой
Орсон буурны шил цоорхой
Ойгүй хүүхдийн зулай цоорхой

Die drei Undichten der Welt

Beim Regenwetter sind die Wolken am Himmel undicht.
Der Nacken eines brunftigen Kamelhengstes ist undicht.
Die Stirn eines Sduglings ist undicht.

Ертөнцийн гурван хэврэг

Эгнэгт батгүй тул энэ нас хэврэг
Үүрд ханилахгүй тул амраг садан
хэврэг
Эцэстээ барагдах тул эд хөрөнгө
хэврэг

Die drei Zerbrechlichen der Welt

Das nicht ewig existierende Leben ist zerbrechlich.
Die/Der nicht ewig bleibende Gatte/in ist zerbrechlich.
Die am Ende verrottenden Habseligkeiten sind zerbrechlich.

(Übersetzung auf Deutsch von A. Tserenchuluun)